



ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ДЭД ЗӨВЛӨЛ ШИНЭЧЛЭН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.1, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтооолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийг бүрэлдэхүүн”-ийг гуравдугаар, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий Дэд зөвлөлийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба (Л.Нямгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам баталж, дэд зөвлөл шинэчлэн байгуулах тухай” Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоолын гурав, тав, зургаа, долоодугаар хавсралтыг, мөн зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 01 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ





Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны 01 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

Гишүүд:

- Улсын ерөнхий прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр);
- Боловсролын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга (тохиролцсоноор);
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (тохиролцсоноор);
- Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Харилцаа, холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын газрын Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга (тохиролцсоноор);
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Хөгжил, нийгмийн оролцооны газрын дарга (тохиролцсоноор);
- Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхим хариуцсан ахлах референт;
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт бус өвчин судлалын хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Жендерийн үндэсний хорооны Ажлын албаны Тогтвортой хөжлийн бодлогын хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга;
- Шүүх шинжилгээний ерөнхий газрын тэргүүн дэд дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн дарга;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын Эрх зүйн хэлтсийн дарга;
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга;
- Хууль зүйн туслалцааны төвийн Мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга;
- Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн профессор;
- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал (зөвшилцсөнөөр);
- "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв" төрийн бус байгууллагын удирдлага (тохиролцсоноор);

- “Монголын хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн” төрийн бус байгууллагын удирдлага (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн.

--00--

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны 5 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

СБТ № 10399

Дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

Гишүүд:

- Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр);
- Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга (тохиролцсоноор);
- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Гадаад харилцааны яамны Консулын газрын гуравдугаар нарийн бичгийн дарга (тохиролцсоноор);
- Боловсролын ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга (тохиролцсоноор);
- Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Халдварт бус өвчин судлалын хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Соёл, спорт, аялал жуулчлал, запуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (тохиролцсоноор);
- Улсын Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхим хариуцсан ахлах референт;
- Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга;
- Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх газрын дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн дарга;
- Шүүх шинжилгээний ерөнхий газрын Нийслэлийн шүүх шинжилгээний газрын Байгалийн ухааны хэлтсийн дарга;
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын Эрх зүйн хэлтсийн дарга;
- Гадаадын иргэн, харьяатын газрын Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга;
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Цахим мэдээлэл, олон нийттэй харилцах төвийн дарга;
- Хууль зүйн туслалцааны төвийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;

- Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал;
- “Хүйсийн тэгш эрх төв” төрийн бус байгууллагын удирдлага (тохиролцсоноор);
- “Анбаунд Монгол” төрийн бус байгууллагын удирдлага (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн.

--00--

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны 01 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

**МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

Гишүүд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик, нөөцийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Соёл, спорт, аялал жуулчлал, запуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (тохиролцсоноор);
- Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга;
- Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга(зөвшилцсөнөөр);
- Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газрын Мэргэжлийн удирдлагын зохицуулалтын хэлтсийн дарга;
- Шүүх шинжилгээний ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга;
- Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн алба, хилийн төлөөлөгчийн газрын дарга;
- Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхмийн профессор;
- Мал эмнэлгийн ерөнхий газрын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны Шуурхай удирдлага, хяналтын төвийн дарга;
- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал (зөвшилцсөнөөр);
- "Монгол малчин мэдээллийн агентлаг"-ийн захирал (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны 1 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга.

Гишүүд:

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (тохиролцсоноор);
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын Техник, технологийн хэлтсийн дарга (тохиролцсоноор);
- Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр);
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн Мэдээллийн технологийн газрын дарга (зөвшилцсөнөөр);
- Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны дарга;
- Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн хэлтсийн дарга;
- Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний газрын дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны Шуурхай удирдлага, хяналтын төвийн дарга;
- Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Цахим мэдээлэл, олон нийттэй харилцах төвийн дарга;
- Нийслэлийн Байгаль орчны газрын дарга;
- Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн профессор;
- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал (зөвшилцсөнөөр);
- Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Байгаль хамгааллын захирал (тохиролцсоноор);
- "Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг" төрийн бус байгууллагын тэргүүн (тохиролцсоноор);
- Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал (тохиролцсоноор).
- Луужин амьтан судлалын нийгэмлэг НҮТББ

Нарийн бичгийн дарга:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн;

- Дэлхийн Байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын Хууль бус агнуур, худалдааны асуудал хариуцсан зөвлөх (тохиролцсоноор).
-

--- o0o ---